



**ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ**

2022 оны 10 сарын 03 өдөр

Дугаар 8/83

Ховд

Ажил хавсран, түр орлон гүйцэтгэгч
томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.1.4, 67.5, Төрийн албаны тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1.2, 43 дугаар зүйлийн 43.3.4, 43.4 дэх заалт, Засгийн газрын 2019 оны 09 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрийн жинхэнэ албан хаагчийн албан үүргийг түр орлон гүйцэтгэхэд цалин, урамшуулал олгох журам”-ыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн Байгаль орчин, аялал жуулчлал, уул уурхай, хүнд үйлдвэрлэлийн бодлого хариуцсан мэргэжилтний албан ажил үүргийг Хөдөө аж ахуй хариуцсан мэргэжилтэн Цэрэндоржийн Пүрэвсүрэнд 2022 оны 09 дүгээр сарын 01-нээс 10 дугаар сарын 29-ний өдөр хүртэл ажил хавсруулан түр орлон гүйцэтгүүлсүгэй.

2. Хөдөө аж ахуй хариуцсан мэргэжилтэн Ц.Пүрэвсүрэнгийн нэмэгдэл хөлсийг үндсэн цалингийн 40 хувиар тооцож олгохыг Санхүү, аж ахуйн тасгийн дарга бөгөөд ерөнхий нягтлан бодогч (Б.Нямдэлгэр)-д зөвшөөрсүгэй.



Д.ЭНХБОЛД